



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 03 өдөр

Дугаар А/140

Чойр

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 46.1.3, 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэг, Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны даргын 2022 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн А/17 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2022 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх “Цөлжилтийг бууруулах зориудаар ойжуулах, байгалийн сэргэн ургалтыг нэмэгдүүлэхэд шаардлагатай зардалд дэмжлэг үзүүлэх Говьсүмбэр” ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:

Б.Болд-Эрдэнэ

(Аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд:

Ц.Энхжаргал

(“Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГазрын дарга)

Д.Оюунсайхан

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн)

Хөндлөнгийн төлөөлөл:

Л.Буяндэлгэр

Нарийн бичгийн дарга:

(Сүмбэр сумын 2 дугаар
багийн иргэн)

Г.Энххишиг

(Аймгийн Засаг даргын Тамгын
газрын Хөгжлийн бодлого,
төлөвлөлт, хөрөнгө
оруулалтын хэлтсийн
мэргэжилтэн)

2.Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Б.Болд-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

3.Үнэлгээний хорооны зөвлөмжид үндэслэн шалгарсан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж, хөрөнгө оруулалтаар бий болсон өмч хөрөнгийг бүртгэл, тайланд тусгаж, эзэмшил ашиглалтад хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Содном)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.БАТЗАМ